



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/334

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дугаар зүйл, Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.3.8, 19.5.3, 19.20.1 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 9 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 5 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 2 хуулийн хуулийн этгээдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Жаргалд үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТЦООЖ

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дугаар сарын 24 -ны өдрийн
1334 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	Өндөр зүрх ХХК /5502012/	Клиник	Ерөнхий мэс засал, Нөхөн сэргээх пластик мэс засал, Арьсны өвчний тусламж үйлчилгээ	ХУД 17 р хороо, Стадион оргил /17012/ Богд Жавзандамба гудамж 34/4 байр 402 тоот
2.	Эстетик грейс ХХК /7192889/	Клиник	Арьсны өвчний тусламж үйлчилгээ	Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангрилла Төвийн, Шангрилла Хотел
3.	Шинэ гүмүда ХХК /7170641/	Клиник	Дотор, Лаборатори, Гэмтэл, Уламжлалт, Дүрс оношилгоо, Эмэгтэйчүүд, Мэс заслын өвчний тусламж үйлчилгээ	Баянзүрх дүүрэг 18-р хороо, Намъяанжүгийн гудамж, 26/1-р байр, 01/24 тоот
4.	Дэлгэрэх бумжүр ХХК /7065361/	Клиник	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	ХУД, 23 дугаар хороо, Арцатын ам, наадамчдын зам, 1439, 99 тоот
5.	Иммуномодул ХХК /5214947/	Клиник	Молекул биологийн Лабораторийн тусламж үйлчилгээ	БГД, 27-р хороо, Жасрайн гудамж 16052 24/1 WM барилгын 3-р давхарт
6.	Маралтун ХХК /5551501/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	СХД, 13-р хороо, 1-р хороолол, 11-р байр 398 тоот
7	Дархан детект ХХК /4251172/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	СБД, 11-р хороо, 7-р хороолол, Элистэйн гудамж, 119 тоот

8	Берен энд лүтиен ХХК /7192313/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	ХУД, 8-р хороо, Наадамчдын зам гудамж, 1207, 52 тоот
9	Жавхаат башир ХХК /6726232/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	ХУД, 3-р хороо, Хос даль оффисын 1 давхарт

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дугаар сарын 24 -ны өдрийн
4/334 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

8025101255 ДТС6291 3077456

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл
1.	Аз жаргал дэлгэрэх ХХК /6863647/	Клиник	Шүдний өвчний мэс заслын тусламж үйлчилгээ
2.	БАСА ХХК /5008646/	Клиник	Арьсны өвчний тусламж үйлчилгээ, Гэмтэл, Гоо сайхны нөхөн сэргээх пластик мэс заслын тусламж үйлчилгээ
3.	Алтан жор ХХК /2847345/	Клиник	Андрологи, Урологи, Протологийн мэс заслын тусламж үйлчилгээ
4.	Нарун дэвш ХХК/6395481/	Клиник	Арьсны өвчний тусламж үйлчилгээ
5.	Хотгойдын хатан шүтээн ХХК/6941745/	Клиник	Лабораторийн тусламж үйлчилгээ /Биохими, Гематологи, Иммунологи, Молекул биологи/